




Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн  
07 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



**ТРАСТ ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН  
МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ЖУРАМ  
(ДОТООД ХЯНАЛТЫН ХӨТӨЛБӨР)**

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.




<i>Хамрах хүрээ:</i> Трастфинанс ББСБ	<i>Хариуцах эзэн:</i> ТРАСТФИНАНС ББСБ ХХК-н комплайнсын ажилтан
<i>Хувийг хадгалах:</i> Гүйцэтгэх захирал	<i>Танилцах:</i> ТРАСТ ФИНАНС ББСБ ХХК-н ажилтнууд
<i>Хүчинтэй хугацаа:</i> 2023.09.26	<i>Хуудасны тоо:</i> 12

**Өөрчлөлтийн түүх:**

№	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1			
2			
3			
4			
5			
6			
7			



Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн  
07 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



## ЖУРМЫН ТОВЬЁОГ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Журмын зорилго
2. Нэр томъёоны тайлбар
3. Баримтлах зарчим

### Хоёр. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа

1. Харилцагч бүртгэх үйл ажиллагаа
2. Харилцагчаас авсан мэдээллийг нягтлах
3. Эцсийн өмчлөгчийг тогтоох
4. Харилцагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт

### Гурав. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа

### Дөрөв. Харилцагчийн эрсдэлийн үнэлгээ

### Тав. Гүйлгээний хяналт хийх үйл ажиллагаа

1. Гүйлгээ хийх үеийн хяналт
2. Гүйлгээ хийсний дараах хяналт
3. Гүйлгээний тусгайлсан хяналт

### Зургаа. Хориглох болон анхаарах жагсаалт

1. Хориглох жагсаалтын дагуу хийх үйл ажиллагаа
2. Анхаарах жагсаалтын дагуу хийх үйл ажиллагаа

### Долоо. Гүйлгээний талаар мэдээлэх үйл ажиллагаа

1. Бэлэн мөнгөний болон гадаад гүйлгээний тайлан
2. Сэжигтэй гүйлгээний тайлан
3. Эрх бүхий байгууллагын лавлагаанд хариу өгөх

### Найм. Харилцагчийн мэдээллийн хадгалалт

### Ес. Сургалт, танин мэдүүлэх үйл ажиллагаа

### Арав. МУТСТ үйл ажиллагааны удирдлага, чиг үүрэг

1. МУТСТ үйл ажиллагааны удирдлагын бүтэц
2. Удирдлагын багийн чиг үүрэг
3. Удирдах ажилтны чиг үүрэг
4. МУТСТ ажилтны эрх үүрэг

### Арван нэг. Хяналт ба хариуцлага

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.





## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


### Журмын зорилго

- 1.1 Траст финанс ББСБ /цаашид “ББСБ” гэх/-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам (Дотоод хяналтын хөтөлбөр) /цаашид "Журам" гэх/-ын зорилго нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, уг үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлогыг тодорхойлж, ББСБ-ын зүгээс авах арга хэмжээ, холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмын бүхий л зохицуулалтад үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.
- 1.3 Энэхүү журмыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /цаашид “МУТСТ” гэж товчлох/ тухай хууль, түүнтэй нийцүүлж эрх бүхий байгууллагаас баталсан журам, тушаал, зааврын хамт дагаж мөрдөнө.
- 1.4 ББСБ нь энэхүү журмыг “Харилцагчийн эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын хамт үйл ажиллагаанд хэрэглэнэ.

### Нэр томъёоны тайлбар

- 1.5 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд тодорхойлсноор, дор дурдсан утгаар ойлгоно.
  - 1.5.1 “Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг
  - 1.5.2 “Терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг
  - 1.5.3 “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг
  - 1.5.4 “Бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг
  - 1.5.5 “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг
  - 1.5.6 “Халхавч банк” гэж аливаа нэг улсад бүртгэлтэй боловч тухайн улсдаа бодит байдлаар оршин байдаггүй банкнийг” гэснийг “гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллагад хамаардаггүй банкнийг
  - 1.5.7 “Харилцагч” гэж байгууллагаар үйлчлүүлж байгаа этгээдийг





- 1.5.8 “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг
- 1.5.9 “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг
- 1.5.10 “Гадаад валютын гүйлгээ” гэж гадаад валютыг худалдах, худалдан авах, түүгээр зээл олгох, баталгаа гаргах үйл ажиллагааг
- 1.5.11 “Харилцагчийг таньж мэдэх” гэж харилцагчтай харилцаа тогтоохоос өмнө болон дараа нь албан ёсны бичиг баримт, эх сурвалж, мэдээллийн эх сурвалж ашиглан тухайн харилцагчийн талаар мэдээллийг тодорхойлж, түүнийг баталгаажуулах үйл явцыг
- 1.5.12 “Харилцагчийн эрсдэл” гэж ББСБ нь МУТСТ тухай хууль болон холбогдох бусад журам, шаардлагын дагуу харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүйгээр тэдгээрт үйлчилгээ үзүүлсний улмаас ББСБ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санхүүгийн болон санхүүгийн бус аливаа эрсдэлийг

#### **Баримтлах зарчим**

- 1.6 ББСБ нь нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, зээл олгох, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахгүй.
- 1.7 ББСБ-ын харилцагч нь МУТСТ тухай хуулийн дагуу шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсан тохиолдолд түүнд үйлчилгээ үзүүлэхгүй
- 1.8 ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх “Харилцагчийн эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бизнесийн харилцаа, гүйлгээнд холбогдох харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.
- 1.9 ББСБ нь халхавч банк болон халхавч банкттай харилцаа тогтоосон банкттай харилцаа тогтоохгүй.
- 1.10 ББСБ нь дараах харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзэж энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.
  - 1.10.1 Улс төрд нөлөө бүхий этгээд
  - 1.10.2 Улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий этгээд /тухайн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч эхнэр, нөхөр-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү/ болон нэгдмэл сонирхолтой этгээд /тухайн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд/;
  - 1.10.3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд /Иран, БНАСАУ, Бахамын арлууд, Ботсвана, Итали, Гхана, Пакистан, Серб, Шри-Ланка, Сири, Тринидад буюу Тобока, Тунис, Емен/;
  - 1.10.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд /Үнэт эдлэлийн худалдаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө зуучлал, ББСБ, санхүүгийн болон хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага, нягтлан бодогч/.
- 1.11 Энэхүү журмыг байгууллагад харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.
- 1.12 ББСБ нь шинэ технологи ашиглан хийгдэж байгаа гүйлгээнд онцгой анхаарч, уг гүйлгээнээс үүсч болох мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.





- 1.13 ББСБ нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхийн өмнө түүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болох эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.14 Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ажилтан нь хууль эрх зүйн эсхүл санхүүгийн мэдлэг боловсролтой, тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг ур чадвартай, ашиг сонирхлын зөрчилгүй, санхүүгийн гэмт хэрэгт ял шийтгэгдээгүй байна.

## **ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ АЖИЛЛАГАА**

### **Харилцагч бүртгэх үйл ажиллагаа**

- 2.1 ББСБ-ын харилцагчтай нүүр тулж үйлчилгээ үзүүлж буй ажилтан нь /цаашид “ББСБ-ын ажилтан” гэх/ харилцагчийг үйлчилгээ авах хүсэлт гаргах, түүнчлэн аливаа гүйлгээ хийх бүрт харилцагчийг таньж мэдэх зорилгоор иргэн, байгууллагын тухай мэдээллийг тодорхойлох Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй, албан ёсны бичиг баримт буюу төрийн байгууллагаас олгосон хүчин төгөлдөр бичиг баримт болон цахим мэдээллийн сангаас гаргуулж авна.
- 2.2 Харилцагчийн ББСБ-тай үүсгэсэн харилцаа нь гуравдагч этгээдийг төлөөлөн хийгдэж байгаа эсэхийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авна. Харилцагч гуравдагч этгээдийг төлөөлөн санхүү, бизнесийн харилцаа үүсгэж байгаа бол эцсийн өмчлөгчийг тогтоох, түүнийг таньж мэдэх боломжит бүх арга хэмжээг авч ажиллана.
- 2.3 ББСБ-ын ажилтан нь шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл шаардах, олж авах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх сурвалжийг ашиглана.
- 2.4 ББСБ-ын ажилтанд журмаас гадуур харилцагч бүртгэх хүсэлт ирэх, нөхцөл үүсэх эсвэл шаардлага гарсан тохиолдолд МУТСТ ажилтанд хандаж харилцагчийн мэдээллийг шалгах асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 2.5 Шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ авах хүсэлт гаргасан харилцагч бүрийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг жагсаалт болон дотоодын анхаарах жагсаалттай тулгаж, улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг тодорхойлно.
- 2.6 ББСБ ажилтан нь харилцагчийн гаргаж өгсөн аливаа албан ёсны бичиг баримтын хүчин төгөлдөр байдалд, түүнийг эрх зүйн зөрчилгүй гэдэгт эргэлзэхгүй байгаа тохиолдолд харилцагчид үйлчилгээ үзүүлнэ.
- 2.7 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд харилцагчаас гаргуулан авсан баримт, мэдээлэл нь худал эсхүл хуурамч болох нь тогтоогдсон бол ББСБ-ын ажилтан нь МУТСТ ажилтанаар дамжуулан сэжигтэй гүйлгээний тайлангаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 2.8 ББСБ нь харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах боломжгүй, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс харилцагч татгалзсан тохиолдолд тухайн этгээдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж өмнө нь үүсгэсэн бизнесийн харилцааг зогсоох арга хэмжээ авч Сэжигтэй гүйлгээний тайлангаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 2.9 Харилцагчийн нэр террорист гэж зарласан этгээдийн нэртэй тохирч байвал, ББСБ нь НҮБ болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон нэмэлт мэдээллийг тулган нягталж тохирч байгаа эсхүл сэжигтэй гэж үзсэн тохиолдолд гүйлгээг түдгэлзүүлж, нэн даруй Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэж гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлнэ.


### **Харилцагчаас авсан мэдээллийг нягтлах**

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.





Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн  
07 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



- 2.10 ББСБ-ын ажилтан нь харилцагчийн гаргаж өгсөн албан ёсны бичиг баримтыг тухайн этгээдэд хамааралтай эсэхийг нягталж, биеийн байцаалтын зурагтай тулгаж шалгана.
- 2.11 Харилцагчаас авсан мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах үйл ажиллагааг дараах шаардлагын дагуу хэрэгжүүлнэ.
- 2.11.1 Харилцагч нь хувь хүн бол дараах бичиг баримтын аль нэгийг шалгаж, иргэнээс авах дэлгэрэнгүй мэдээлэл маягтыг бөглүүлнэ. Үүнд:
- 2.11.1.1 Иргэний үнэмлэх /цахим үнэмлэх/
  - 2.11.1.2 Гадаад паспорт
  - 2.11.1.3 Улсын бүртгэгчээс олгосон иргэний үнэмлэхний лавлагаа
  - 2.11.1.4 ТҮЦ машины лавлагаа
  - 2.11.1.5 ХУР системээс авсан лавлагаа
- 2.11.2 Харилцагч нь хуулийн этгээд бол дараах бичиг баримтыг шалгаж, байгууллагаас авах дэлгэрэнгүй мэдээлэл маягтыг бөглүүлнэ. Үүнд:
- 2.11.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ
  - 2.11.2.2 Аж ахуйн нэгжийн дүрэм
  - 2.11.2.3 Эцсийн өмчлөгчийн иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортын хуулбар
  - 2.11.2.4 ХУР системээс авсан лавлагаа

#### **Эцсийн өмчлөгчийг тогтоох**

- 2.12 ББСБ нь харилцагчийн эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно. Үүнд:
- 2.12.1 Хуулийн этгээдийн хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;
  - 2.12.2 Энэ журмын 2.12.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
  - 2.12.3 Энэ журмын 2.12.1 болон 2.12.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

#### **Харилцагчийн хувийн хэрэг бүрдүүлэлт**

- 2.13 Харилцагчийн хувийн хэрэг нь харилцагчийн талаар хангалттай мэдээллийг агуулахын зэрэгцээ харилцагчийн ББСБ-тай үүсгэсэн санхүү, бизнесийн харилцааны мөн чанар зорилго, хөрөнгө, орлогын эх үүсвэрийн талаарх мэдээллийг агуулсан байна.
- 2.14 Харилцагчийн хувийн хэрэг гэдэгт дараах бичиг баримтуудыг ойлгоно:
- 2.14.1 Харилцагчийн албан ёсны бичиг баримтын хуулбар;
  - 2.14.2 Үйлчилгээ авах хүсэлт, анкет;
  - 2.14.3 Бүтээгдэхүүн үйлчилгээний гэрээ;
- 2.15 ББСБ-ын холбогдох ажилтан нь нийт харилцагчдын хувийн хэргийн бүрдүүлбэр бүрэн эсэхэд тогтмол хугацаанд хяналт тавиж, шалгаж баталгаажуулна.

#### **ГУРАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НАРИЙВЧИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1 Журмын 1.10.1, 1.10.2, 1.10.3 болон 1.10.4-д заасан өндөр эрсдэлтэй харилцагч болон эцсийн өмчлөгчийг тодорхойлоход харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.2 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.





- 3.2.1 Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтална.
- 3.2.2 Өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагааг бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь зээлийн хүсэлтйн маягтыг бүрэн бөглүүлж шаардлагатай тохиолдолд төрийн мэдээлэл солилцооны системээр баталгаажуулна.
- 3.3 Дараах тохиолдолд харилцагчийн өмнө нь өгсөн мэдээллийг дахин нягтална.
  - 3.3.1 Харилцагч өндөр дүнтэй гүйлгээ хийх тохиолдолд
  - 3.3.2 Харилцагчийн гүйлгээний төрөл, давтамж, утга, дүн гэх хэв шинжид өөрчлөлт ажиглагдсан тохиолдолд
  - 3.3.3 Харилцагчийн талаар өмнө нь олж авсан мэдээлэл нь санхүүгийн харилцааны шинж чанарыг тодорхойлоход хангалтгүй байгаа тохиолдолд
- 3.4 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд харилцагчаас гаргуулан авсан баримт, мэдээлэл нь худал эсхүл хуурамч болох нь тогтоогдсон бол ББСБ-ын ажилтан нь МУТСТ ажилтнаар дамжуулан Сэжигтэй гүйлгээний тайлангаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

#### **ДӨРӨВ. ХАРИЛЦАГЧИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

- 4.1 ББСБ нь дараах эрсдэлийн хүчин зүйлсийг тусгасан “Харилцагчийн эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ийн дагуу харилцагчийн эрсдэлийг үнэлж тодорхойлно.
  - 4.1.1 Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;
  - 4.1.2 Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл;
  - 4.1.3 Бүтээгдэхүүн үйлчилгээ тэдгээрийг харилцагчид хүргэх арга, хэлбэр болон гүйлгээнээс хамаарч үүсэх эрсдэл;
  - 4.1.4 Гүйлгээнээс хамаарч үүсэх эрсдэл;
  - 4.1.5 Бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл;

#### **ТАВ. ГҮЙЛГЭЭНД ХЯНАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 5.1 ББСБ нь харилцагчийн хийгдсэн аливаа гүйлгээ бүрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 5.2 ББСБ нь гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэх явцад харилцагчаас нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулж болох ба шаардлагатай тохиолдолд үр дүнг бичгээр хадгална.

##### **Гүйлгээ хийх үеийн хяналт**


- 5.3 ББСБ-ын харилцагчтай нүүр тулж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ажилтан бүр харилцагчид үйлчилгээ үзүүлэх үедээ гүйлгээтэй холбоотой этгээдийн мэдээллийг нягтлан шалгаж энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан холбогдох арга хэмжээг авч ажиллана. Мөн энэхүү журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлнэ.

##### **Гүйлгээ хийсний дараах хяналт**

- 5.4 ББСБ-ын МУТСТ ажилтан нь ажлын 5 хоног бүр нийт харилцагчийн хийсэн гүйлгээнд хяналт тавьж энэхүү журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу Сэжигтэй гүйлгээний талаар мэдээлнэ.

##### **Гүйлгээний тусгайлсан хяналт**

- 5.5 ББСБ нь дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавьж ажиллана:



- 5.5.1 Огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
  - 5.5.2 Эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
  - 5.5.3 Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;
  - 5.5.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн;
  - 5.5.5 Энэхүү журмын 4.1-т заасан “Харилцагчийн эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон харилцагчийн хийсэн.
- 5.6 ББСБ нь энэ журмын 5.5-д заасан гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгална.

### **ЗУРГАА. ХОРИГЛОХ БОЛОН АНХААРАХ ЖАГСААЛТ**

#### **Хориглох жагсаалтын дагуу хийх үйл ажиллагаа**

- 6.1 ББСБ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад нийцүүлэн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу баталсан хориг арга хэмжээний жагсаалт /цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхгүй.
- 6.2 ББСБ нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ.

#### **Анхаарах жагсаалтын дагуу хийх үйл ажиллагаа**

- 6.3. ББСБ нь мөнгө уаалт болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд харилцагчийн эрсдэлийг удирдах үүднээс дараах төрлийн анхаарах жагсаалтыг үйл ажиллагаандаа хэрэглэж энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу харилцагчийн эрсдэлийн түвшинд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
  - 6.3.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий /FATF/олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч;
  - 6.3.2 Дотоод болон гадаадын улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалт;
  - 6.3.3 ББСБ-ын үйл ажиллагааны туршид олж авсан эрсдэлтэй иргэн, хуулийн этгээдийн жагсаалт болон бусад төрлийн жагсаалт;

### **ДОЛОО. ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **Бэлэн мөнгөний тайлан**

- 7.1 ББСБ нь харилцагчид 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөөр олгосон зээлийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 7.2 ББСБ нь дээрх мэдээллийг мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангаж, цахим хэлбэрээр эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлнэ.

#### **Сэжигтэй гүйлгээний тайлан**





- 7.3 Зээл олголт болон зээлийн эргэн төлөлтийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол ББСБ нь энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 7.4 Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна.
  - 7.4.1 ББСБ-ын нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
  - 7.4.2 Харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;
  - 7.4.3 Тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;
  - 7.4.4 Тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;
- 7.5 Сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдэд үйлчилгээ үзүүлэхэд ашигласан бичиг баримтын хуулбар, харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас шаардсан тохиолдолд ББСБ нь мэдээллийг шаардлагын дагуу хүргүүлнэ.
- 7.6 ББСБ-ын удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг МУТСТ хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.
- 7.7 ББСБ-ын удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчид мэдэгдэхийг хориглоно.

#### **Эрх бүхий байгууллагын лавлагаанд хариу өгөх**

- 7.8 ББСБ нь эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг шаардсан тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу гаргаж өгнө.

#### **НАЙМ. ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАДГАЛАЛТ**

- 8.1 ББСБ нь харилцагчийн хийсэн гүйлгээ болон харилцагчийн талаар энэхүү журмын дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн харилцагчтай харилцаа зогсоосон эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 8.2 ББСБ нь энэхүү журмын 8.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.
- 8.3 Энэ журмын 4.1-т заасан эрсдэлийн үнэлгээнд ашигласан баримт, мэдээллийг таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах ба энэ хугацаанд эрх бүхий хянан шалгагч, улсын байцаагчийн шаардсан даруйд гарган өгөхөд бэлэн байлгана.
- 8.4 Харилцагчаас авсан мэдээлэл, баримт материалыг шүүх үйл ажиллагаанд нотлох баримтын түвшинд ашиглах боломжийг хангаж байхаар архивлаж хадгална.

#### **ЕС. СУРГАЛТ, ТАНИН МЭДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 9.1 ББСБ нь МУТСТ үйл ажиллагааны талаарх сургалт танин мэдүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг жил бүр баталж, холбогдох төсвийг батална.
- 9.2 ББСБ-ын МУТСТ асуудал хариуцсан ажилтан нь удирдах болон нийт ажилтнуудад МУТСТ-тэй холбоотой цаг үеийн шинж чанартай чухал мэдээллээр тогтмол хангана.

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.





Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн  
07 тоот тушаалын 01 дүгээр хавсралт

- 9.3 ББСБ нь МУТСТ өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтныг үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай мэргэжлийн сургалтанд тогтмол хамруулна.
- 9.4 ББСБ нь шинэ ажилтнуудаа МУТСТ үйл ажиллагааны талаар ерөнхий ойлголт өгөх сургалтанд заавал хамруулна.
- 9.5 Сургалт, танин мэдүүлэх үйл ажиллагааг холбогдох нэгж дангаараа эсхүл бусад хэлтэс нэгж, болон гадны сургалтын байгууллагатай хамтран танхимын болон цахим хэлбэрээр явуулж болно.
- 9.6 Сургалтын үр дүнг тухай бүр шалгаж, сургалтын тайланг бэлтгэж холбогдох удирдлага болон удирдлагын багт тайлагнадаг байна.
- 9.7 ББСБ нь энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг зохих албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарьт оруулж, баталсан байна.

## **АРАВ. МУТСТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЧИГ ҮҮРЭГ**

### **МУТСТ үйл ажиллагааны удирдлагын бүтэц**

- 10.1 ББСБ-ын МУТСТ үйл ажиллагааны удирдлага нь дараах бүтэцтэй байна.
  - 10.1.1 МУТСТ үйл ажиллагаатай холбоотой өөрийн хариуцсан чиг үүргээ гүйцэтгэдэг нийт ажилтан;
  - 10.1.2 МУТСТ-тэй тэмцэх өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх үүрэг бүхий 1 болон түүнээс дээш ажилтан. Энэхүү удирдах ажилтан нь ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад шууд мэдээлэл өгөх эрхтэй байна;
  - 10.1.3 МУТСТ-тэй холбоотой асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах эрх бүхий удирдлагын баг;

### **Удирдлагын багийн чиг үүрэг**

- 10.2 Энэхүү журмын 10.1.3-д заасан удирдлагын баг нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
  - 10.2.1 МУТСТ үйл ажиллагааны тайлантай сар бүр танилцаж холбогдох шийдвэрийг гаргана;
  - 10.2.2 Өндөр эрсдэлтэй харилцагчтай цаашид харилцаагаа үргэжлүүлэх эсэх шийдвэр;
  - 10.2.3 Өндөр эрсдэлтэй харилцагчтай шинээр харилцаа үүсгэх эсэх асуудал;
  - 10.2.4 МУТСТ үйл ажиллагаанд баримтлах хэрэгжүүлэх журмыг батлах, тэдгээрт орох нэмэлт өөрчлөлтийг батлах;
  - 10.2.5 МУТСТ үйл ажиллагаатай холбоотой бусад төрлийн асуудал;

### **МУТСТ асуудал хариуцсан ажилтны чиг үүрэг**

- 10.3 Энэхүү журмын 10.1.2-д заасан ажилтан нь дараах эрх үүрэгтэй байна.
  - 10.3.1 МУТСТ үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн журам, аргачлалыг холбогдох хууль, тогтоомжтой нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгоно. Удирдлагын багаар батлуулж, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавина.
  - 10.3.2 Энэхүү журмын 9 дүгээр бүлэгт заасан сургалт, танин мэдүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох төсвийг батлуулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавина.
  - 10.3.3 ББСБ-ын нийт ажилтнуудыг өдөр тутмын удирдлагаар хангаж, түүний үйл ажиллагаанд хяналт тавина.
  - 10.3.4 ББСБ-ын холбогдох бүх баримт бичиг, тэр дундаа харилцагч болон гүйлгээний талаарх баримт, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнаас гаргуулан авах эрхтэй байна.
  - 10.3.5 МУТСТ чиглэлээр холбогдох байгууллагад хуулийн дагуу тайлагнах, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх ажил үүргийг хариуцах.

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.



10.3.6 ББСБ нь МУТСТ ажилтны аюулгүй байдлыг хангаж, мэдээллийг хамгаалах нөхцөлийг хангаж ажиллана.

### АРВАН НЭГ. ХЯНАЛТ БА ХАРИУЦЛАГА

- 11.1 ББСБ нь МУТСТ үйл ажиллагааны тогтолцоонд жилд 1 удаа эрсдэлд үнэлгээ хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэхүү үнэлгээг ажлын хэсэг байгуулж эсхүл мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно. Энэхүү үнэлгээг хийхдээ дараах зүйлсийг тусгасан байна.
- 11.1.1 ББСБ-ын МУТСТ үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт оновчтой байгаа эсэх;
- 11.1.2 Монгол Улсын хууль болон олон улсын энэ чиглэлийн нийтлэг шаардлагад нийцэж байгаа эсэх;
- 11.1.3 Энэхүү журмын хэрэгжилт хангагдаж байгаа эсэх, холбогдох албан тушаалтан, ажилтнууд үүргээ биелүүлж байгаа эсэх;
- 11.1.4 Тухайн салбар нэгжийн холбогдох албан тушаалтан, ажилтнуудын МУТСТ талаарх мэдлэг чадвар хангалттай байгаа эсэх;
- 11.1.5 Холбогдох сургалт үр дүнтэй, хуваарийн дагуу явагдаж байгаа эсэх;
- 11.1.6 Холбогдох тайлан, мэдээг удирдлагад болон холбогдох газруудад хугацаанд нь гаргаж өгч байгаа эсэх;
- 11.1.7 Харилцагчийн мэдээллийг Санхүүгийн мэдээллийн алба болон бусад эрх бүхий төрийн байгууллагад хуулийн хүрээнд хүргүүлж байгаа эсэх
- 11.2 Энэхүү журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу Удирдлагын баг, МУТСТ ажилтан зэрэг өөрийн чиг үүргийн дагуу холбогдох хяналтыг тогтмол хэрэгжүүлнэ.
- 11.3 МУТСТ чиглэлээрх ББСБ үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг эрх бүхий байгууллага, хөндлөнгийн аудитын байгууллага болон ББСБ-ын дотоод хяналт хариуцсан ажилтан хянана.
- 11.4 ББСБ нь МУТСТ дотоод журам, хяналтын хэрэгжилт үр дүнтэй байдалд давхар хяналт тавих чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагаас хараат бус, ажил үүргээ гүйцэтгэх хангалттай нөөц бололцоогоор хангагдсан дотоод хяналтын ажилтантай байна.
- 11.5 ББСБ-ын удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад МУТСТ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг ББСБ-ын, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.
- 11.6 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох Монгол Улсын хууль, түүнтэй уялдуулан гаргасан дүрэм, журам болон ББСБ-ын дотоод журмын дагуу арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэнэ.